



**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 5.1.3, 30.1.12 дугаар заалтууд, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.13.1, 5.1.13.2, 5.1.13.3 заалтуудын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хэрэглэгчдээс дуудлага хүлээн авах, дуудлага барагдуулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг харьяа салбарын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтсийн дарга /Ц.Эрдэнэчимэг/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2014 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/72 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ШҮРЭНЧУЛУУН

121210141



ХЭРЭГЛЭГЧДЭЭС ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ, ДУУДЛАГА БАРАГДУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Хэрэглэгчдийн цахилгаан хангамж тасалдсан, тоног төхөөрөмжид гэмтэл саатал гарсан талаар хэрэглэгчдээс ирсэн дуудлагыг хүлээн авч, чанартай, түргэн шуурхай, соёлтой үйлчилгээг үзүүлэх, ажилчдын ажлын сахилга бат, хариуцлага, хяналтыг дээшлүүлэх мөн харьяа салбар, нэгж хэсгүүдийн хоорондын ажлын уялдаа холбоог зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Дагаж мөрдөх ажилтнууд

- 2.1 Компанийн харьяа салбар, нэгж хэсгүүдийн хангах хэсгийн бүх ажилтнууд
 - 2.2 Компанийн харьяа салбар, нэгж хэсгүүдийн Шуурхай үйлчилгээний бүх ажилтнууд
 - 2.3 Харьяа салбарын Хангах хэсгийн танхимын ажилтнууд
 - 2.4 Харьяа салбарын Хангах хэсгийн дуудлагын монтерүүд
 - 2.5 Сумдууд дахь байцаагч монтер болон, Шуурхай үйлчилгээ засварын монтерүүд
- Гурав. Холбогдох дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, стандарт
- 3.1 "Эрчим хүчний тухай хууль" Монгол Улсын, 2001 он
 - 3.2 "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм" Монгол Улсын Засгийн Газрын тогтоол, 2020 он, дугаар 97
 - 3.3 "Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага" MNS 5872:2008 Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн тогтоол, 2008 он, дугаар 35

Дөрөв. Хэрэглэгдэх нэр томъёонууд

- 4.1 **Дуудлага** гэж цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох хүсэлт ирүүлсэн болон холбогдсон хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан, цахилгаан тоног төхөөрөмжид нь гэмтэл, согог гарсан тохиолдлуудад хэрэглэгчээс цахилгаан хангамжаа сэргээлгэх талаар ирүүлсэн хүсэлтийг хэлнэ.
- 4.2 **Дуудлагын үйлчилгээний мэдээллийн сан** гэж дуудлагыг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минут, хэрэглэгчийн нэр хаяг, байршил, холбоо барих утас, гэмтлийн байдал, хүчдэл тасарсан өдөр, цаг, минут, хүчдэл тасарсан шалтгаан, цахилгаан эрчим хүчний хангамж тасалдсан хүрээ, дуудлагыг барагдуулсан алба нэгж, хүний нэр, дуудлагыг барагдуулахад авсан арга хэмжээ, дуудлагыг барагдуулсан хугацаа, хэрэглэгчээс дуудлагын чанарт өгсөн үнэлгээ, огноо зэргийг тусгасан мэдээллийн санг хэлнэ.
- 4.3 **Дуудлагын монтер** гэж дуудлагыг барагдуулах үүрэг бүхий монтер, сумдуудад шуурхай үйлчилгээ засварын монтерүүдыг хэлнэ.
- 4.4 **Дуудлага хүлээн авагч** харьяа салбарууд хэрэглэгчдээс дуудлага хүлээн авч, дамжуулан, хуваарилах, дуудлага барагдуулах үйлчилгээг зохион байгуулах үүрэг бүхий ажилтныг хэлнэ.

Тав. Дуудлагаар хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээний зааг

- 5.1. Дуудлагаар хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээний заагийг Хавсралт.2-т харуулав.

Зургаа. Дуудлага үйлчилгээнд хэрэглэгдэх холбооны хэрэгслүүд

6.1 Компанийн харьяа салбаруудын хангах хэсэг нь дуудлага барагдуулах үйл ажиллагааны үед хоорондоо болон Шуурхай үйлчилгээ засварын монтер дуудлагын монтер, бригадтай харьцахад хэрэглэгдэх технологийн удирдлагын зориулалттай холбооны үндсэн хэрэгсэл нь Монголын цахилгаан холбооны АТС-ын телефон утас, үүрэн телефон операторуудын сүлжээний гар утаснууд байна.

Долоо. Дуудлага хүлээн авах

7.1 Компанийн харьяа салбарууд нь өөрсдийн эзэмшил, үйлчилгээний хүрээний орон нутаг, аймгийн төв, сум, суурин газруудын хэрэглэгчдээс ирэх дуудлагыг салбарын төв дээр тусгай зориулалтын дугаараар хүлээн авна.

7.2 Харьяа салбаруудын дуудлага хүлээн авч барагдуулах зааг, дуудлага хүлээн авах утасны дугаарыг Хавсралт. 3 -т харуулав.

Найм. Дуудлагыг хүлээн авах цагийн хуваарь

8.1 Харьяа салбаруудын хангах хэсгүүд нь өөрсдийн эзэмшлийн зааг, үйлчлэх хүрээний хэрэглэгчдээс ирэх дуудлагыг долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гаригууд буюу ажлын өдрүүдэд 08:00 цагаас 17:00 цаг хүртэл хүлээн авч ажиллана. 17:00 цагаас дараа өдрийн өглөөний 08:00 цагт хүртэл, Бямба, Ням гаригуудад хоногийн 24 цаг салбарын шуурхай үйлчилгээний хэсэг дээр ээлжийн инженер дуудлагыг хүлээн авна.

8.2 Харьяа салбарууд нь өөрсдийн эзэмшлийн зааг, үйлчлэх хүрээний хэрэглэгчдээс ирэх дуудлагыг нийтээр амрах амралт баяр ёслолын өдрүүдэд 24 цагаар салбаруудын шуурхай үйлчилгээний хэсэг дээр ээлжийн инженер хүлээн авна.

Ес. Дуудлага хүлээн авах телефон утасны дуудлагыг шилжүүлэх

9.1 Харьяа салбаруудын хангах хэсгүүд нь өөрсдийн эзэмшлийн зааг, үйлчлэх хүрээний хэрэглэгчдээс ирэх дуудлагыг долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гаригууд буюу ажлын өдрүүдэд 08⁰⁰ – 17⁰⁰ цаг хүртэл Монголын цахилгаан холбооны 70.....-тай телефон утсаар хүлээн авч ажиллах бөгөөд 17⁰⁰ цагаас дараа өдрийн 08⁰⁰ цаг хүртэл дуудлага хүлээн авах телефон утасны дуудлагыг тус тусынхаа салбарын шуурхай үйлчилгээний хэсэгт тавигдах шаардлагын дагуу шилжүүлнэ.

9.2 Харьяа салбаруудын шуурхай үйлчилгээний хэсгүүд нь хэрэглэгчдээс ирэх дуудлага хүлээн авах телефон утасны дуудлагыг ажлын өдрүүд буюу долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гаригуудад 08⁰⁰ цагт тус тусын хангах хэсэгт тавигдах шаардлагын дагуу шилжүүлнэ.

9.3 Тоног төхөөрөмжийн томоохон ноцтой гэмтэл, аваар гарсан талаар болон хүний амь настай холбоотой дуудлага орж ирсэн үед салбарын хангах хэсгийн дуудлага хүлээн авч байгаа ажилтан нь өөрөө бие даан хариулт өгөх боломжгүй бол дуудлагыг хүлээн авч, энэ талаарх мэдээлийг харьяа салбарын шуурхай үйлчилгээний хэсэгт түргэн мэдэгдэнэ. Хэрэв дуудлагыг автоматаар шууд шилжүүлэх техникийн боломжтой бол салбарын шуурхай үйлчилгээ ээлжийн инженертэй шууд холбож яриулна.

Арав. Дуудлага хүлээн авалтыг шилжүүлэх үед мэдээлэл солилцох

10.1 Дуудлага хүлээн авах үйлчилгээг хангах хэсгээс шуурхай үйлчилгээний хэсэгт, шуурхай үйлчилгээний хэсгээс хангах хэсэгт шилжүүлэн өгөх буюу авах үед дараах мэдээллүүдийг "Дуудлага хүлээн авах журнал"-д бүртгэж, тэмдэглэх буюу харилцан солилцоно.

10.1.1 Тухайн өдөр, ээлжийн хугацаанд дуудлага хүлээн авч ажилласан, дуудлагын үйлчилгээг шилжүүлэн хүлээн авч ажиллах ажилтны овог нэр, албан, тушаал, мэргэжлийн зэрэг, групп

10.1.2 Тухайн өдөр, ээлжийн хугацаанд ирсэн дуудлагын тоо

10.1.3 Түүнээс хийж гүйцэтгэсэн дуудлагын тоо

10.1.4 Түүнээс хийж гүйцэтгээгүй дуудлагын тоо, хаяг, шалтгаан

10.1.5 Дуудлагыг барагдуулах талаар дуудлагын монёрууд болон сумдын байцаагч монёруудад мэдэгдсэн дуудлага, тоо

10.1.6 "Дуудлага хүлээн авах үйлчилгээ"-г шилжүүлэх үеийн огноо.

Арван нэг. Дуудлагыг бүртгэх

11.1 Хэрэглэгчдээс ирэх дуудлагыг бүртгэхдээ хүлээн авсан цаг, хэрэглэгчийн нэр, хаяг, байршил, холбоо барих утас, гэмтлийн байдал, хүчдэл тасарсан өдөр, цаг, минут, тасарсан шалтгаан, цахилгаан эрчим хүчний хангамж тасалдсан хүрээ зэргийг нарийвчлан тусгаж, тодорхойлон авч "Дуудлага хүлээн авах журнал"-д, дуудлагыг хэнд дамжуулсан тухай мэдээллийн хамт бүртгэж авна.

11.2 Хэрэглэгчдээс ирэх дуудлагыг бүртгэж авахдаа, цахилгаан эрчим хүчээр түдгэлзүүлсэн хэрэглэгчдийн жагсаалтанд бүртгэгдсэн эсэхийг шалгаж, бүртгэж авна.

11.3 Харьяа салбаруудын хангах болон түгээх хэсгүүд дээр ирсэн хэрэглэгчдийн дуудлагыг хангах хэсэг дээр нэгтгэн тухай бүрт нь дуудлага хүлээн авах журналд бүртгэсний дараа EDiMIS системийн MarketIndicator программ-д оруулж дуудлагын мэдээллийн санг бүрдүүлж ажиллана. Мөн дуудлага барагдуулсан талаарх гүйцэтгэлийг мэдээллийн санд дэлгэрэнгүй байдлаар тэмдэглэнэ.

11.4 Дуудлага хүлээн авах дугаар дээр бичигдсэн яриаг хуанлын 30 хоног хугацаатай архивлана. Хэрэглэгчээс гомдол гарсан тохиолдолд тус архивлагдсан яриа баримт болгон ашиглана.

11.5 Дуудлага хүлээн авах дугаар дээр ирсэн дуудлага бүрт дуудлага хүлээн авагч хариу өгч ажиллана. Алдагдсан буюу хариу өгөөгүйгээс бүртгэгдсэн дугаар руу буцаан залгаж тус дуудлагыг барагдуулна.

11.6 Дуудлага хүлээн авах дугаар дээр ирсэн алдагдсан болон барагдуулсан дуудлага бүрийг дуудлага хүлээн авах журнал дээр бүртгэнэ.

Арван хоёр. Дуудлага дамжуулах, хуваарилах

12.1 Харьяа салбаруудын хангах, түгээх хэсэг дээр хүлээн авсан дуудлагыг дуудлага хүлээн авсан ажилтан, ээлжийн инженерүүд нь 15 минутаас ихгүй хугацаанд үйлчлэх хүрээ, эзэмшлийн заагаар нь дуудлагын монёрууд, сумдын шуурхай үйлчилгээ, засварын монёрт дамжуулан хуваарилна.

Арван гурав. Дуудлага барагдуулах

13.1 Харьяа салбаруудын хангах хэсгийн дуудлагын монтерүүд, сумдуудын шуурхай үйлчилгээ, засварын монтерүүд нь Хавсралт-2-т заасан заагийн хүрээнд хэрэглэгчдээс ирсэн дуудлагыг Хавсралт-3 заагдсан нормчилсон хугацаанд багтааж барагдуулж, хийж гүйцэтгэнэ. Тус нормчилсон хугацааг дуудлага бүртгэсэн хугацаанаас эхэлж тооцно.

13.2 Харьяа салбаруудын сумдын шуурхай үйлчилгээ засварын монтерүүд нь долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан өдрүүдэд 08⁰⁰ цагаас 17⁰⁰ цаг хүртэл салбарын хангах хэсгийн дуудлага хүлээн авагчаас, Бямба, Ням гаригууд болон нийтээр амрах баяр, ёслолын өдрүүд, өвлийн улиралд 17:00 цагаас 19:00 цаг хүртэл, зун, хавар, намрын улиралд 21:00 цаг хүртэл дараа өдрийн 08⁰⁰ цаг хүртэл салбарын шуурхай үйлчилгээний хэсгийн ээлжийн инженерээс дуудлагыг хүлээн авч барагдуулж, хариу мэдээлэл өгч ажиллана.

13.3 Харьяа салбаруудын дуудлагын монтерүүд нь нь долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, Бямба, Ням гариг болон нийтээр амрах баяр, ёслолын өдрүүдэд 08⁰⁰ цагаас 17⁰⁰ цаг хүртэл салбарын хангах хэсгийн дуудлага хүлээн авагчаас, 17⁰⁰ цагаас дараа өдрийн 08⁰⁰ цаг хүртэл салбарын шуурхай үйлчилгээний хэсгийн ээлжийн инженерээс дуудлагыг хүлээн авч барагдуулж, хариу мэдээлэл өгч ажиллана.

13.4 Долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан, гаригууд буюу ажлын өдрүүдэд 17⁰⁰ цагаас хойш дараа өдрийн 08⁰⁰ цаг хүртэлх хэрэглэгчдээс ирэх дуудлагыг харъяа салбаруудын шуурхай үйлчилгээ хэсэг дээр ээлжийн инженер хүлээн авах ба дуудлагыг шуурхай үйлчилгээ засварын монтерүүд барагдуулж ажиллана.

13.5 Нийтээр амрах баяр ёслолын өдрүүд нь нэг хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх тохиолдолд Шуурхай үйлчилгээ засварын монтер 24 цагаар хэрэглэгчдийн дуудлагыг барагдуулж ажиллуулна.

13.6 Харьяа салбаруудын хангах хэсэг нь Хавсралт-2-т заасны дагуу гэр хорооллын тоолуурын нэгтгэсэн щит, орон сууцны ерөнхий щитнээс тэжээгдэж байгаа 0.4 кВ сүлжээнд гарсан бүх дуудлагыг барагдуулна. Дуудлага хүлээн авч ажиллаж байгаа ажилтан нь түгээх хэсэгт хамаарагдах дуудлагыг ээлжийн инженерт дамжуулах буюу дуудлага өгсөн хэрэглэгчийг ээлжийн инженертэй холбож өгнө.

13.7 Хэрэв дуудлагыг барагдуулах үйл явц нь шуурхай үйлчилгээ, түгээх хэсэгтэй хамтран гүйцэтгэх шаардлагатай бол энэ тухай шуурхай үйлчилгээний хэсгийн ээлжийн инженер, салбарын хангах хэсгийн дуудлага хүлээн авагчид мэдэгдэнэ.

13.8 Харьяа салбаруудын төв ажлын байр дээр ажиллаж байгаа дуудлагын болон сумдын шуурхай үйлчилгээ засварын монтерүүд нь дуудлагыг газар дээр нь үзэж гэмтлийн шинж чанар, шалтгааныг тодорхойлон шаардлагатай арга хэмжээг авч, цахилгаан эрчим хүчний төлбөрөөс шалтгаалан түдгэлзүүлснээс бусад тохиолдолд хэрэглэгчийн цахилгаан хангамжийн тасалдлыг сэргээнэ.

13.9 Тухайн дуудлага нь эзэмшлийн зааг, үйлчлэх хүрээнд хамрагдахгүй, хэрэглэгчийн эзэмшлийн заагт хамаарагдах зэрэг бол дуудлагыг буцаах буюу дуудлага хүлээн авагч нь дараагийн авч болох арга хэмжээний талаар дуудлага өгөгчид тайлбар хийнэ.

Арван дөрөв. Дуудлагын гүйцэтгэлийг бүртгэх, төлбөр тооцоо

14.1 Дуудлагыг барагдуулж, бүрэн хийж гүйцэтгэсний дараагаар уг ажлын гүйцэтгэлийн талаар дуудлага хүлээн авч ажиллаж байгаа ажилтанд мэдэгдэж, "Дуудлагын журнал"-д бүртгүүлнэ.

14.2 Дуудлага хэрхэн барагдуулсан, ямар ажилбар хийгдсэн талаар мэдээллийг дуудлага хүлээн авсан ажилтан бүрэн тодруулж, компанийн батлагдсан төлбөрт үйлчилгээний тарифын дагуу төлбөрийг тооцон тухайн дуудлага өгсөн хэрэглэгчийн код, хаяг нэрээр

тулгалт хийж төлбөрт үйлчилгээний баримт үйлдэн баримтын дагуу MarketIndicator программ-д бичилтийг оруулж хэрэглэгчээс нэхэмжилнэ.

14.3 Хэрэглэгч дуудлага үйлчилгээний төлбөрийг цахимаар болон бэлнээр, салбарын касс, өөрийн харилцагч банк-д тухайн сарын цахилгаан эрчим хүчний төлбөртэй хамт төлөх боломжтой.

14.4 Тухайн сарын 25-ны өдрөөс хойш хэрэглэгчдээс ирсэн дуудлагын төлбөрийг дараа сарын дуудлагын мэдээнд тусгаж, цахилгаан эрчим хүчний төлбөрийн хамт нэхэмжилнэ.

Арван тав. Дуудлага үйлчилгээний мэдээ, тайлан

15.1 Харьяа салбаруудын хангах хэсгүүд нь дуудлага үйлчилгээний мэдээллийн санг бүрдүүлэн байнга, тасралтгүй хөтлөн ажиллаж, сар бүрийн эхний 5 хоногт багтаан өмнөх сард хийгдсэн "Дуудлага үйлчилгээ"-ний тайлан нэгтгэлийг 2018 онд Санхүү хангах үйл ажиллагаа хариуцсан Дэд захирлаар батлуулсан Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэст харьяа салбаруудын хангах үйл ажиллагаа хариуцсан менежер, борлуулалтын инженерүүдээс ирүүлэх мэдээ тайлангийн жагсаалтад заасан хавсралт №11 маягтын дагуу гарган ирүүлж ажиллана.

Арван зургаа. Ажилтнуудын хүлээх хариуцлага

16.1 Энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллаагүй, хэрэглэгчдэд дуудлага үйлчилгээг үзүүлэх явцдаа ажлын дутагдал, доголдол гаргасан, хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан ажилтнуудад "Хөдөлмөрийн тухай" хууль, "Компанийн дотоод журам" болон бусад хууль, дүрэм, журмын заалтуудыг удирдлага болгон зохих шийтгэлийг ноогдуулна.

16.2 Дуудлага хүлээн авагч нь хэрэглэгчийн дуудлагыг авахгүй, дуудлага барагдуулах хугацааг удаашруулсан, хэрэглэгчтэй зүй бусаар харьцсан нь нотлогдвол зохих журмын дагуу хариуцлага тооцно.

16.3 Дуудлага барагдуулагч дуудлагын монтер нь батлагдсан хугацаанаас илүү хугацаагаар дуудлага барагдуулсан, хэрэглэгчийн дуудлагыг санаатайгаар удаашруулсан нь нотлогдвол зохих журмын дагуу хариуцлага тооцно.

Хэрэглэгчдээс дуудлага хүлээн авах,

дуудлага барагдуулах үйлчилгээ журмын хавсралт-2

<i>д/д</i>	<i>Дуудлагын үйлчилгээг гүйцэтгэгч</i>	<i>Үйлчилгээний хүрээ, үйл ажиллагааны удирдлагын ерөнхий зааг</i>	<i>Хийгдэх ажлын нэр</i>
1	Компанийн ХҮАХБХ, салбаруудын хангах хэсгийн ИТА, дуудлагын монтерууд	Гэр хорооллын 0.22кВ, 0.4кВ-ын ЦДАШ-аас тоолуур нэгтгэсэн щит рүү буусан буултын кабелин эхний үзүүрийн холболтоос хэрэглэгч тал руу	Тоолуур нэгтгэсэн щитэнд тоолуур, гүйдлийн трансформатор, пакет, автомат солих, айлын оруулгын утсыг шинээр холбох, тайлах, гэмтлийг олох, солих, нэгтсэн щитэнд автомат залгах, таслах, айлын гэрт розетка, унтраалга

			суурилуулах, солих, хэмжилт хийх.
2		Орон сууцны ерөнхий щитний 0.4 кВ-ын ерөнхий автомат, рубильникээс хэрэглэгч тал руу	Ерөнхий щит, тоолуур нэгтгэсэн щит, давхарын щитэнд тоолуур, гүйдлийн трансформатор, пакет, автомат солих, айлын оруулгын утсыг шинээр холбох, тайлах, гэмтлийг олох, солих, нэгдсэн щитэнд автомат залгах, таслах, айлын гэрт розетка, унтраалга суурилуулах, солих, хэмжилт хийх
3		Компанийн болон хэрэглэгчийн эзэмшлийн трансформаторын дэд станцад 0.4 кВ-ын ерөнхий щит дэх хэрэглэгчийн тоолуур, түүний холболтын кабель, 0,4кВ-ын гүйдлийн трансформатор	Хэрэглэгчийн тоолуур, гүйдлийн трансформатор дээр холболт хийх, сольж тавих, гэмтэл тодорхойлох, хэмжилт хийх, заалт авах. Хэрэглэгчийн пакет, автоматыг таслах, залгах, солих, оруулгын утас солих.
4	Компанийн ТҮАХБХ, салбаруудын түгээх хэсгийн ИТА, монтёрууд	Гэр хорооллын 0,22кВ, 0,4кВ-ын ЦДАШ, АТП, ТП, КТПН, РП-ны өндөр, нам талын тоноглолууд, 0,4кВ-ын щит, Орон сууцны ерөнхий щитний оруулгын кабель	0.22кВ, 0.4кВ-ын агаарын болон кабель шугамд гэмтэл олох, сэргээн засварлах, аваар устгах, АТП, ТП, КТПН, РП-ны өндөр, нам талын бүх тоноглолууд, 6-35кВ-ын түгээх сүлжээнд хийгдэх бүх төрлийн ажлууд
5	Сумдуудын шуурхай үйлчилгээ, засварын монтёрууд	Сумын доторх гэр хорооллын 0,22кВ, 0,4кВ-ын ЦДАШ, АТП, ТП, КТПН, РП-ны өндөр, нам талын тоноглолууд, 0,4кВ-ын щит, Гэр хороолол Орон сууцны ерөнхий щит, давхарын щит, кабель	0.22кВ, 0.4кВ-ын агаарын болон кабель шугамд гэмтэл олох, сэргээн засварлах, аваар устгах, АТП, ТП, КТПН, РП-ны өндөр, нам талын бүх тоноглолууд, 6-35кВ-ын түгээх сүлжээнд хийгдэх бүх төрлийн ажлууд, Тоолуур нэгтгэсэн щитэнд тоолуур, гүйдлийн трансформатор, пакет, автомат солих, айлын оруулгын утсыг шинээр холбох, тайлах, гэмтлийг олох, солих, нэгтсэн щитэнд автомат залгах,

			таслах, айлын гэрт розетка, унтраалга суурилуулах, солих, хэмжилт хийх.
6	Шуурхай үйлчилгээний хэсэг	6-35 кВ-ын түгээх сүлжээнд	0.22кВ, 0.4кВ-ын агаарын болон кабель шугамд гэмтэл олох, сэргээн засварлах, аваар устгах, АТП, ТП, КТПН, РП-ны өндөр, нам талын бүх тоноглолууд, 6-35кВ-ын түгээх сүлжээнд хийгдэх бүх төрлийн ажлууд, хэмжилт хийх, ажлын байр бэлтгэх, ажилд оруулах.

*Хэрэглэгчдээс дуудлага хүлээн авах,
дуудлага барагдуулах үйлчилгээ журмын хавсралт-3*

Д/Д	Салбарын нэр	Дуудлага хүлээн авах утасны дугаар	Дуудлага үйлчилгээ үзүүлэх цэгүүд
1	Багануур ЦТСС	70210404	1. Улаанбаатар хотын Багануур дүүрэг, 2. Төв аймгийн Мөнгөнморьт сум 3. Хэнтий аймгийн Жаргалтхаан сум, 4. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, 5. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум,
2	Говьсүмбэр ЦТСС	70543702	1. Говьсүмбэр аймгийн төв Сүмбэр сум, 2. Говьсүмбэр аймгийн Баянтал сум, 3. Говьсүмбэр аймгийн Шивээговь сум, 4. Дорноговь аймгийн Даланжаргалан сум, 5. Дорноговь аймгийн Айраг сум, 6. Дорноговь аймгийн Өндөршил сум, 7. Дорноговь аймгийн Алтанширээ сум 8. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, 9. Хэнтий аймгийн Дархан сум, 10. Дундговь аймгийн Баянжаргалан сум, 11. Дундговь аймгийн Цагаандэлгэр сум, 12. Дундговь аймгийн Говь-Угтаал сум 13. Дорноговь аймгийн Иххэт сум
3	Дорноговь ЦТСС	70522327	1. Дорноговь аймгийн төв Сайншанд сум, 2. Дорноговь аймгийн Өргөн сум, 3. Дорноговь аймгийн Замын-Үүд сум, 4. Дорноговь аймгийн Улаанбадрах сум, 5. Дорноговь аймгийн Хөвсгөл сум, 6. Дорноговь аймгийн Хатанбулаг сум, 7. Дорноговь аймгийн Мандах сум,

			8. Дорноговь аймгийн Сайхандулаан сум, 9. Дорноговь аймгийн Дэлгэрэх сум,
4	Дундговь ЦТСС	70592500	1. Дундговь аймгийн төв Сайнцагаан сум, 2. Дундговь аймгийн Луус сум, 3. Дундговь аймгийн Хулд сум, 4. Дундговь аймгийн Дэлгэрхангай сум, 5. Дундговь аймгийн Адаацаг сум, 6. Дундговь аймгийн Эрдэнэдалай сум, 7. Дундговь аймгийн Дэрэн сум, 8. Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, 9. Дундговь аймгийн Гурвансайхан сум, 10. Дундговь аймгийн Өлзийт сум, 11. Өмнөговь аймгийн Цогт-овоо сум,
5	Хэнтий ЦТСС	70562323	1. Хэнтий аймгийн төв Хэрлэн сум, 2. Хэнтий аймгийн Баянхутаг сум, 3. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум, 4. Хэнтий аймгийн Баян-Адрага сум, 5. Хэнтий аймгийн Биндэр сум, 6. Хэнтий аймгийн Батширээт сум, 7. Хэнтий аймгийн Дадал сум, 8. Хэнтий аймгийн Норовлин сум, 9. Хэнтий аймгийн Батноров сум, 10. Хэнтий аймгийн Баян-Овоо сум, 11. Хэнтий аймгийн Галшар сум, 12. Хэнтий аймгийн Баянмөнх сум, 13. Хэнтий аймгийн Мөрөн сум, 14. Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум,

*Хэрэглэгчдээс дуудлага хүлээн авах,
дуудлага барагдуулах үйлчилгээ журмын хавсралт-4*

Д/Д	Дуудлагын төрөл	Дуудлага барагдуулах дундаж хугацаа /мин/
1	Шинэ холболт	66.0
2	Төрөл бүрийн гэрлийн шил солих	36.0
3	Гал хамгаалагч солих, шинээр тавих - 220В, 380В	15.0
4	Автомат солих - 220В, 380В	42.0
5	Рубильник солих	56.0
6	Пускатель тавих	79.0
7	Унтраалга, розетка тавих, солих, патрон угсрах, сэрээ /вилк/ солих, засварлах	39.0
8	Тоолуурыг хэлхээнээс авах, тавих -220В, 380В	52.0
9	Гүйдлийн трансформатор угсрах, холбох /3 ш/	60.0
10	Гүйдлийн трансформатор хүчдлээс салгах /3 ш/	35.0

11	Тоолуурт гадны хэрэглээ орсон эсэхийг шалгах	38.0
12	Дотор монтаж хийх -220В, 380В	76.0
13	Дотор монтаж шалгах, гэмтэл олох -220В, -380В	89.0
14	Хэрэглэгчийн щит монтажлах	59.0
15	Хэрэглэгчийн щитэнд засвар үйлчилгээ хийх	72.0
16	Хамгаалалтаар тасарсан хэрэглэгчдийг залгах	38.0
17	ЦЭХ-ний төлбөр тооцоо төлөөгүйгээс таслагдсан хэрэглэгчийг залгах	38.0
18	Тулгуурт гарч кабелийн үзүүр холбох, тайлах	57.0
19	Кабелийн залгаас хийх /1ш залгаас хийхэд/ -220В, 380В	54.0
20	Кабель шугамын гэмтэлтэй эсэхийг шадгах	48.0
21	Хэрэглэгчийн кабель утас солих - 220В, 380В	60.0
22	Гагнуур оруулганд холбох, салгах - 220В, 380В	42.0
23	Тоолуургүй нөхцөлд 1 цаг гагнуур холбох, тайлах - 220В, 380В	78.0
24	Урьдчилсан төлбөрт тоолуур цэнэглэх	18.0
25	Хэрэглэгч өөрсдөө хэвийн болгосон	23.0
26	Нэгдсэн щитэнд гарсан гэмтэл устгах	69.0
27	Хэрэглэгчийн хүсэлтээр хүчдэл таслуулж залгуулах	35.0
28	Тоолуурын лабораторит 1 фазын импульсийн тоолуурт программ уншуулах	27.0
29	Тоолуурын лабораторит 1 фазын импульсийн тоолуур баталгаажуулах	23.0
30	Тоолуурын лабораторит 3 фазын импульсийн тоолуурт программ уншуулах	30.0
31	Тоолуурын лабораторит 3 фазын импульсийн тоолуур баталгаажуулах	27.0